



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/24

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэст тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг аймгийн сонгуулийн хорооны дарга (Ө.Сувдаа), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Саранчимэг) нарт зөвлөсүгэй.
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (аудитор О.Анхбаяр)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Батмөнх)-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА

018010075



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН  
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН  
ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

АЙМАГ, СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРОО БОЛОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТЭС НЬ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ  
ХООРОНД ГҮЙЛГЭН ЗАРЦУУЛСАН БАЙНА



Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)  
Аудитын менежер Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)  
Аудитор О.Анхбаяр  
Утас: 70362442 Цахим хаяг: [ankhbayaro@audit.gov.mn](mailto:ankhbayaro@audit.gov.mn)  
Аудитор Ж.Баясгалан  
Утас: 70362442 Цахим хаяг: [bayasgalanj@audit.gov.mn](mailto:bayasgalanj@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. [Open.audit.mn](http://Open.audit.mn)

## **АГУУЛГА**

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгтийн товьёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

### **Бүлэг 1. Орон нутгийн ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх?**

1.1. Сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

1.2. Зарим сумдын сонгуулийн хорооны төсвийг төлөвлөснөөс илүү олгосон байна.

1.3. Сонгогчийн болон итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

### **Бүлэг 2. Орон нутгийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?**

2.1. УБХ нь итгэмжлэгдсэн ажилтны урамшууллын зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг СЕХ-ноос баталсан журмын дагуу тайлагнасан байна.

2.3. Аймгийн сонгуулийн хорооноос сумын болон хэсгийн хороодод төсвийн зарцуулалт, тайлагналын талаар сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.

## **АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ**

### **ДҮГНЭЛТ**

### **ЗӨВЛӨМЖ**

### **САНАЛ**

## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
МТД	Мэдээлэл технологийн даамал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал

## Хүснэгтийн товъёг:

*Хүснэгт 1. Сэлэнгэ аймагт хуваарилсан санхүүжилт*

*Хүснэгт 2. Аймгийн сонгуулийн хорооноос хуваарилсан санхүүжилт /зардлын нэр, төрлөөр/*

*Хүснэгт 3. Аймаг, сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт*

*Хүснэгт 4. УБЕГ-аас аймгийн УБХ-т хуваарилсан санхүүжилт*

*Хүснэгт 5. Аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /аймаг, сумдаар/*

*Хүснэгт 6. УБХ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл*

*Хүснэгт 7. Сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /зардлын нэр төрлөөр/*

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/100 дугаар тушаал, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийв.

### **Аудитын зорилт:**

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, аудитын тайланг ҮАГ-ын ГНАГ, аймгийн сонгуулийн хороо, УБХ болон холбогдох бусад байгууллагад хүргүүлж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд:

- *Орон нутгийн ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;*
- *Орон нутгийн ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.*

### **Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагуудыг хамруулна.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоол;
- СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”;
- СЕХ-ны Тамгын газрын даргын 2024 оны А/68 дугаар тушаалаар баталсан “Аймаг” нийслэл сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны сонгуулийн Сэлэнгэ аймгийн сонгуулийн хорооны төсөв”;
- Холбогдох бусад хууль эрхийн актууд.

#### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор О.Анхбаяр, Ж.Баясгалан нар 2024 оны 11 дугаар сарын 08-аас 12 дугаар сарын 11-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

#### **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг 10 дугаар сарын 11-ны өдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 176 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бол аймгийн сонгуулийн хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор сумдын сонгуулийн хороог тус бүр 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 9, сумдын сонгуулийн хороонд 99, хэсгийн хороодод 537, мэдээллийн технологийн 87 даамал, цагдаагийн байгууллагын ажилтан 124, улсын бүртгэлийн ажилтан 63 зэрэг нийт **919** төрийн албан хаагч ажилласан байна.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд **848,067.0** мянган төгрөгийн төсөв хуваарилж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

УБЕГ-аас нэрсийн жагсаалт хэвлэх, санал авах техник хэрэгслийг тээвэрлэх болон түүнтэй холбогдсон албан хаагчийн сургалт зохион байгуулах болон мөнгөн урамшуулал, унаа, хоолны зардалд нийт **49,625.6** мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан байна.

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ИТХ-Н СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.**

**1.1. Сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.**

**1.1.1** Сэлэнгэ аймагт 2024 оны орон нутгийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс олгох зардлын хэрэгцээ шаардлагыг сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо, тэдгээрийн байршил, хоорондын зай зэрэг бусад шаардлагатай мэдээлэлд үндэслэн тодорхойлж, төсвийг хуваарилсан байна.

**1.1.2** Дээрх үзүүлэлтүүдийг үндэслэн хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, унааны зардал, мэдээ дамжуулах зардлыг тооцоолж, төлөвлөсөн бол бичиг хэрэг, сургалт сурталчилгаа, шуудан холбооны зардлыг тогтмол байхаар тооцож, ирүүлсэн байна.

**1.2. Зарим сумдын сонгуулийн хорооны төсвийг төлөвлөснөөс илүү олгосон байна.**

**1.2.1** СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд 6 удаагийн удирдамжийн дагуу нийт **848,067.0** мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 1. Сэлэнгэ аймагт хуваарилсан санхүүжилт**

*/мянган төгрөг/*

№	Зардлын нэр төрөл	2024.08.19	2024.09.05	2024.09.13	2024.09.23	2024.09.27	2024.10.05	Нийт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,360.0						1,360.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал			38,658.0				38,658.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой зардал			1,300.0	3,217.0	3,200.0	1,770.0	9,487.0
4	Санал авах байр бэлтгэх зардал		17,640.0		5,460.0	14,670.0		37,770.0
5	Сонгуулийн байгууллагын ажилтан болон, МТБ-ийн гишүүн, даамал, нөөц даамлын сургалт, сурталчилгааны зардал	30,816.0	170.0	20,000.0				50,986.0
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал						610,960.0	610,960.0
7	Бичиг хэргийн зардал		11,110.0					11,110.0
8	Шуудан, холбооны зардал		13,500.0					13,500.0
9	Унааны зардал		54,880.0					54,880.0
10	Албан томилолтын зардал			14,064.0				14,064.0
11	Болзошгүй зардал						5,292.0	5,292.0
<b>Нийт дүн</b>		<b>32,176.0</b>	<b>97,300.0</b>	<b>74,022.0</b>	<b>8,677.0</b>	<b>17,870.0</b>	<b>618,022.0</b>	<b>848,067.0</b>

**Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан**

**1.2.2** Аймгийн сонгуулийн хорооны даргын 5 удаагийн захирамжаар **848,067.0** мянган төгрөгийн санхүүжилтийг аймаг, сумын сонгуулийн хороодод хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 2. Аймгийн сонгуулийн хорооноос хуваарилсан санхүүжилт /зардлын нэр, төрлөөр/**  
/мянган төгрөг/

№	Зардлын нэр төрөл	2024.08.25	2024.09.06	2024.09.16	2024.09.27	2024.10.06	Нийт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,360.0					1,360.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал			38,658.0			38,658.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой зардал			1,300.0	6,417.0	1,770.0	9,487.0
4	Санал авах байр бэлтгэх зардал		17,640.0		11,310.0		28,950.0
5	Сонгуулийн байгууллагын ажилтан болон, МТБ-ийн гишүүн, даамал, нөөц даамлын сургалт, сурталчилгааны зардал	30,816.0	170.0	20,000.0			50,986.0
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал					610,960.0	610,960.0
7	Бичиг хэргийн зардал		11,110.0				11,110.0
8	Шуудан, холбооны зардал		13,500.0				13,500.0
9	Унааны зардал		54,880.0		8,820.0		63,700.0
10	Албан томилолтын зардал			14,064.0			14,064.0
11	Болзошгүй зардал					5,292.0	5,292.0
<b>Нийт дүн</b>		<b>32,176.0</b>	<b>97,300.0</b>	<b>74,022.0</b>	<b>26,547.0</b>	<b>618,022.0</b>	<b>848,067.0</b>

**Эх сурвалж:** Аймгийн сонгуулийн зардлын тайлан

**1.2.3** Захирамжийн дагуу аймгийн сонгуулийн хороонд 74,839.1 мянган төгрөг, сумдын сонгуулийн хороонд 773,227.9 мянган төгрөг, нийт **848,067.0** мянган төгрөгийг хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 3. Аймаг, сумдын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт**

/мянган төгрөг/

№	Сумын нэр	Сумын сонгуулийн хорооны тоо	Санал авах байрны тоо	Төлөвлөгөө	Санхүүжилт	Хэтрэлт/хэмнэлт
1	Алтанбулаг	1	3	40,434.5	40,434.5	-
2	Баруунбүрэн	1	3	37,019.3	37,019.3	-
3	Баянгол	1	3	41,464.5	42,004.5	540.0
4	Ерөө	1	3	40,934.5	40,934.5	-
5	Жавхлант	1	2	28,405.7	28,405.7	-
6	Зүүнбүрэн	1	3	38,821.7	38,821.7	-
7	Мандал	1	15	163,317.3	163,317.3	-
8	Орхон	1	2	25,758.9	25,758.9	-
9	Орхонтуул	1	3	37,119.3	37,119.3	-
10	Сайхан	1	4	49,857.7	49,857.7	-
11	Сант	1	2	28,995.7	28,995.7	-
12	Сүхбаатар	1	8	86,843.7	86,843.7	-
13	Түшиг	1	2	25,553.9	25,553.9	-
14	Хушаат	1	2	25,258.9	25,538.9	280.0
15	Хүдэр	1	2	25,608.9	25,608.9	-
16	Цагааннуур	1	3	39,151.7	39,151.7	-
17	Шаамар	1	3	38,681.7	38,681.7	-
<b>Сумын дүн</b>		<b>17</b>	<b>63</b>	<b>773,227.9</b>	<b>774,047.9</b>	<b>820.0</b>
18	Аймаг			74,839.1	74,019.1	(820.0)

Нийт дүн	17	63	848,067.0	848,067.0	0.0
----------	----	----	-----------	-----------	-----

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан

**1.2.4** Гүйцэтгэлээр сумдын сонгуулийн хороонд төлөвлөгөөний дагуу 773,227.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч Баянгол, Хушаат сумдад нөхөн санал хураалт явуулсны зардалд 820.0 мянган төгрөг нэмж, нийт **774,047.9** мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### 1.3. Сонгогчийн болон итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна.

**1.3.1** УБЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 тушаалаар сонгогчийн тоо, итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил, хоорондын зайг үндэслэн нийт **49,625.6** мянган төгрөгийн санхүүжилтийг Сэлэнгэ аймгийн УБХ-т хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

#### Хүснэгт 4. УБЕГ-аас аймгийн УБХ-т хуваарилсан санхүүжилт

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	27,472.5
2	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх	3,314.1
3	Сонгогчийн нэрсийн жагсаалт хүргэх	2,140.0
4	Сургалтын зардал	10,863.0
5	Тоног төхөөрөмж тээвэрлэх багийн зардал	1,136.0
6	Тоног төхөөрөмж тээвэрлэх автобусны зардал	4,400.0
7	Сонгуулийн өдөр ажиллах шуурхай багийн зардал	300.0
	<b>Нийт дүн</b>	<b>49,625.6</b>

Эх сурвалж: УБХ-ийн зардлын тайлан

## БҮЛЭГ 2. СУРГАЛТ, СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ АШИГЛАХ, УРАМШУУЛАЛ, ХООЛНЫ ЗЭРЭГ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭС ШАЛТГААЛАН НИЙТ ЗАРДАЛ 2.5 ХУВИАР ХЭМНЭГДЖЭЭ.

### 2.1. УБХ нь итгэмжлэгдсэн ажилтны урамшууллын зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

**2.1.1** СЕХ-ноос Сэлэнгэ аймгийн сонгуулийн хорооны төсвийг нийт **848,067.0** мянган төгрөгөөр баталж, хуваарилснаас **826,514.7** мянган төгрөгийг зарцуулж, **21,552.3** мянган төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна. Аймаг, сумдын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

#### Хүснэгт 5. Аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /аймаг, сумдаар/

/мянган төгрөг/

№	Сумын нэр	Сумын сонгуулийн хорооны тоо	Санал авах байрны тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
1	Алтанбулаг	1	3	40,434.5	40,192.7	(241.8)
2	Баруунбүрэн	1	3	37,019.3	37,019.3	-
3	Баянгол	1	3	41,464.5	42,004.5	540.0
4	Ерөө	1	3	40,934.5	40,899.3	(35.2)
5	Жавхлант	1	2	28,405.7	28,405.7	-

6	Зүүнбүрэн	1	3	38,821.7	36,212.8	(2,608.9)
7	Мандал	1	15	163,317.3	163,317.3	-
8	Орхон	1	2	25,758.9	25,608.9	(150.0)
9	Орхонтуул	1	3	37,119.3	37,003.8	(115.5)
10	Сайхан	1	4	49,857.7	47,832.7	(2,025.0)
11	Сант	1	2	28,995.7	28,995.7	-
12	Сүхбаатар	1	8	86,843.7	86,405.7	(438.0)
13	Түшиг	1	2	25,553.9	25,553.9	-
14	Хушаат	1	2	25,258.9	25,538.9	280.0
15	Хүдэр	1	2	25,608.9	25,608.9	-
16	Цагааннуур	1	3	39,151.7	39,151.7	-
17	Шаамар	1	3	38,681.7	38,646.5	(35.2)
	<b>Сумын дүн</b>	<b>17</b>	<b>63</b>	<b>773,227.9</b>	<b>768,398.3</b>	<b>(4,829.6)</b>
18	Аймаг			74,839.1	58,116.4	(16,722.7)
	<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>63</b>	<b>848,067.0</b>	<b>826,514.7</b>	<b>(21,552.3)</b>

*Эх сурвалж: Аймагын сонгуулийн зардлын тайлан*

**2.1.2** Сумдын нийт дүнгээр төлөвлөсөн зардлыг **4,829.6** мянган төгрөгөөр хэмнэсэн нь нөхөн санал хураалт явагдсан Баянгол сум 540.0 мянган төгрөгөөр, Хушаат сум 280.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн болон Зүүнбүрэн сум 2,608.9 мянган төгрөгөөр, Сайхан сум 2,025.0 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

**2.1.3** Аймагын сонгуулийн хороо нь нийт төлөвлөсөн зардлыг **16,772.8** мянган төгрөгөөр хэмнэсэн бөгөөд зардлын хэмнэлтэд дараах 3 төрлийн зардал голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- **Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой зардал:** СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон,
- **Сургалт, сурталчилгааны зардал:** СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон,
- **Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал:** Сумдын 50-60 хувьд санал тэнцэж нөхөн сонгууль явагдах магадлалтай гэж үзэн СЕХ-оос өндрөөр төлөвлөж ирсэн, зардлыг гүйцэтгэлээр тооцож олгосон,

**2.1.4** Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны зардлыг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад нийт **3,436.0** төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

**Аймаг:** Сумдын сонгуулийн хорооны хүсэлтийг үндэслэн **685.0** мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулах эрх олгосон байна. Энэ нь СЕХ-ны Тамгын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 3/777 дугаар албан бичгийн хавсралтаар баталсан “*Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар*”-ын анхаарч ажиллах зүйлсийн 1 дэх “*Хуваарилсан төсвийг эдийн засгийн ангилал хооронд нь шилжүүлэхгүй байх, ...*” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- *Ерөө сум нь даамлын сургалтын зардлаас 170.0 мянган төгрөгийг саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцааж хүргэж өгөх зардалд,*
- *Мандал сум нь маягт хэвлэх зардлаас 72.5 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд,*

- Сант сум нь даамлын сургалтын зардлаас 390.0 мянган төгрөгийг саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцааж хүргэж өгөх зардалд,
- Шаамар сум нь маягт хэвлэх зардлаас 52.5 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд.

**Сумд:** Нийт 3 сум, **1,710.0** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

- Жавхлант сум: Байр бэлтгэх зардлаас 260.0 мянган төгрөгийн 4 уртасгагч, 50 мянган төгрөгийн нэрийн хуудасны сав худалдаж авсан зэрэг 310.0 мянган төгрөг,
- Хүдэр сум: Сурталчилгааны зардлаас сонгуулийн хорооны шатахуунд 600.0 мянган төгрөг зарцуулсан,
- Шаамар сум: Сурталчилгааны зардлаас бичиг хэргийн зардалд 800.0 мянган төгрөг зарцуулсан.

**2.1.5** УБЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 тушаалаар аймгийн УБХ-т **49,625.6** мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан боловч гүйцэтгэлээр **50,008.6** мянган төгрөг олгож, **383.0** мянган төгрөгөөр илүү санхүүжүүлсэн байна. Санхүүжилтийг УБХ-ийн нэмэлт санхүүжилтийн 100130012420 дугаар дансанд төвлөрүүлж, зарцуулан хэмнэлт **1,152.7** мянган төгрөгийг УБЕГ-ын 100900012093 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 6. УБХ-ийн зардлын төлөвлөгөө, санхүүжилт, гүйцэтгэл**

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Санхүүжилт	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт
1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	27,472.5	27,472.5	31,046.4	3,573.9
2	Сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх	3,314.1	3,314.1	1,462.5	(1,851.6)
3	Сонгогчийн нэрсийн жагсаалт хүргэх	2,140.0	2,140.0	1,790.0	(350.0)
4	Сургалтын зардал	10,863.0	10,863.0	8,721.0	(2,142.0)
5	Тоног төхөөрөмж тээвэрлэх багийн зардал	1,136.0	1,136.0	1,136.0	-
6	Тоног төхөөрөмж тээвэрлэх автобусны зардал	4,400.0	4,400.0	4,400.0	-
7	Сонгуулийн өдөр ажиллах шуурхай багийн зардал	300.0	300.0	300.0	-
8	Илүү санхүүжилт		383.0	-	(383.0)
	<b>Нийт дүн</b>	<b>49,625.6</b>	<b>50,008.6</b>	<b>48,855.9</b>	<b>(1,152.7)</b>

**Эх сурвалж:** УБХ-ийн зардлын тайлан

**2.1.6** УБХ-ийн сонгуулийн зардлыг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- УБЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 тушаалаар аймгийн УБХ-т итгэмжлэгдсэн ажилтны урамшууллыг 37 хүнд 27,472.5 мянган төгрөг олгохоор баталсан боловч гүйцэтгэлээр 42 итгэмжлэгдсэн төлөөлөгч ажиллаж 31,046.4 мянган төгрөг буюу 5 хүний урамшууллын **3,573.9** мянган төгрөгийг сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх болон сургалтын зардлаас гүйлгэн зарцуулж олгосон байна.

**2.1.7** Аймгийн УБХ нь томилолтын хуудсыг холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулалгүйгээр 392.0 мянган төгрөгийн томилолтын зардал тооцож, олгосон зөрчлийг аудитын явцад томилолтын хуудаст бичилт хийлгэж, залруулав.

## 2.2. Зардлын гүйцэтгэлийг СЕХ-ноос баталсан журмын дагуу тайлагнасан байна.

2.2.1 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу сонгуулийн зардлын тайланг гаргаж, нэгтгэсэн байна.

2.2.2 Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэж, тайлагнасан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зардлын ангиллаар харуулбал:

**Хүснэгт 7. Сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /зардлын нэр төрлөөр/**

*/мянган төгрөг/*

№	Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,360.0	780.0	(580.0)
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, сумын сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах авах зардал	38,658.0	38,332.0	(326.0)
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой зардал	9,487.0	5,970.0	(3,517.0)
4	Санал авах байр бэлтгэх зардал	28,950.0	28,531.0	(419.0)
5	Сонгуулийн байгууллагын ажилтан болон, МТБ-ийн гишүүн, даамал, нөөц даамлын сургалт, сурталчилгааны зардал	50,986.0	45,538.2	(5,447.8)
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	610,960.0	602,824.3	(8,135.7)
7	Бичиг хэргийн зардал	11,110.0	10,987.2	(122.8)
8	Шуудан, холбооны зардал	13,500.0	13,100.0	(400.0)
9	Унааны зардал	63,700.0	62,930.0	(770.0)
10	Албан томилолтын зардал	14,064.0	12,230.0	(1,834.0)
11	Болзошгүй зардал	5,292.0	5,292.0	-
<b>Нийт дүн</b>		<b>848,067.0</b>	<b>826,514.7</b>	<b>(21,552.3)</b>

*Эх сурвалж: Аймгийн сонгуулийн зардлын тайлан*

2.2.3 СЕХ-оос 11 төрлийн зардалд нийт **848,067.0** мянган төгрөгийн төсөв баталж, хуваарилсныг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан байна.

## 2.3. Аймгийн сонгуулийн хорооноос сумын болон хэсгийн хороодод төсвийн зарцуулалт, тайлагналын талаар сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.

2.3.1 СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.10-т “... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, ... зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

2.3.2 Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу сумдын сонгуулийн хороодод нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлэх, санхүүжилтийг арвилан хэмнэлтэй зарцуулах, үнэн зөв тайлагнах, зарцуулалтад хяналт тавих, 2020 оны УИХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах зэрэг асуудлаар 1 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан байна.

**2.3.3** Сумдын сонгуулийн хороодын нягтлан бодогчдын групп үүсгэн, мэдээ, мэдээлэл, үүрэг чиглэл, зөвлөмж өгч, “Сонгуулийн төсвийн зарцуулалтын тухай” зөвлөмжийг бэлтгэн файл хэлбэрээр бүх сумдад хүргүүлсэн байна.

### **АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ**

Аудитаар нийт **5,968.9** мянган төгрөгийн зөрчил илрүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

#### **Зөвлөмж:**

- Сумдын сонгуулийн хорооны хүсэлтийг үндэслэн **685.0** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулах эрх олгож, зарцуулсан,
- Нийт 3 сум нь 1,710.0 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан,
- УБХ нь 3,573.9 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан.

### **ДҮГНЭЛТ**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- Сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум, хэсгийн хороодын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна,
- Зарим сумдын сонгуулийн хорооны төсвийг төлөвлөснөөс илүү олгосон байна.
- Сонгогчийн болон итгэмжлэгдсэн ажилтны тоо, сумдын байршил зэрэг мэдээлэлд үндэслэн зардлын төсвийг хуваарилсан байна,
- УБХ нь батлагдсан итгэмжлэгдсэн ажилтны тоог хэтрүүлснээс урамшууллын зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна,
- Зардлын гүйцэтгэлийг СЕХ-ноос баталсан журмын дагуу тайлагнасан байна.
- Аймгийн сонгуулийн хорооноос сумын болон хэсгийн хороодод төсвийн зарцуулалт, тайлагналын талаар сургалт хийж, зөвлөмж хүргүүлсэн байна.

### **ЗӨВЛӨМЖ**

**Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:**

**Аймгийн сонгуулийн хорооны дарга Ө.Сувдаа, нягтлан бодогч П.Баярцэцэг нарт:**

1. Сумдын сонгуулийн хорооны төсвийг батлагдсан зориулалтын дагуу зарцуулахаар хуваарилж байх,

2. Сумдын сонгуулийн хорооны хуваарилагдсан төсвийн зарцуулалтад үр нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлж, зардлын тайланг хуваарилсан төсөвтэй тулган хүлээж авах.

**Аймгийн УБХ-ийн дарга Б.Саранчимэг, нягтлан бодогч М.Мягмар нарт:**

1. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангасан ажил, гүйлгээг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, бүртгэл тайланд тусгах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР  
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА  
Б.БАТМӨНХ  
О.АНХБАЯР  
Ж.БАЯСГАЛАН

# АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС ИРҮҮЛСЭН САНАЛ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг  
Утас/Факс: 7036-3966

2024.12.13 № 41

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ДАРГА  Ө СУВДАА